

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн 29-р хуралдааны тэмдэглэл /2012-12-14/**

Ажлын хэсгийн хуралдаан 2012 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 11 цагт Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд эхлэв.

Хуралдаанд Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа, Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Батхүү, мэргэжилтэн Б.Хулан, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын мэргэжилтэн Ж.Ивээлэн, мэргэжилтэн Г.Зулай, Татварын ерөнхий газрын мэргэжилтэн Д.Энхтуяа, Ашигт малтмалын газрын хэлтсийн дарга Б.Бямбадагва, мэргэжилтэн Д.Мөнхсайхан, Авилгатай тэмцэх газрын мэргэжилтэн А.Дэлгэрбаяр, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Эрдэнэт таван толгой ХК-ийн төлөөлөгч Д.Санчир, Оюу толгой ХХК-ийн төлөөлөгч О.Адъяа, Нээлттэй нийгэм форумын менежер Н.Дорждарь, Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөний тэргүүн Б.Баярмаа, Ил тод сангийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Миний Монголын газар шороо хөдөлгөөний тэргүүн С.Отгонсайхан, Монголын Байгаль орчныг хамгаалах холбооны удирдах зөвлөлийн гишүүн Д.Сэнгэлмаа, Байгаль эхийн аврал сан ТББ-ийн тэргүүн Н.Наранцэцэг, Монголын Байгаль орчны иргэний зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд, Хүний эрх хөгжил төвийн төлөөлөгч Б.Байгальмаа, ажлын албаны зохицуулагч, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Ш.Цолмон нар оролцов. Хуралдаанд ажлын хэсгийн 33 гишүүдээс 19 гишүүн оролцож ирц 57 хувьтай байв.

Мөн хуралдаанд урилгаар Европын сэргээн босголт хөгжлийн банкны ахлах эдийн засагч Пол Моффат, Адам Смит хүрээлэнгийн захирал Жонатан Пэлл, хурал зохион байгуулагчаар ажлын албаны санхүүгийн мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нар оролцов.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: ОҮИТБС-ын хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэх хүрээнд хэрэгжүүлэх Европын сэргээн босголт хөгжлийн банкны төслийн шинэчилсэн төлөвлөгөө

Н.Баярсайхан: За баярлалаа. Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас санаачилгыг дэмжиж төсөл хэрэгжүүлэхээр болсон ба төсөл нь 2011 оны 8 сард эхэлсэн боловч тодорхой шалтгаануудын улмаас сүүлийн хэдэн саруудад төсөл түр саатсан байсан. Тэгээд төслийг үргэлжлүүлэх, дахин эхлүүлэх зорилгоор төсөл хэрэгжүүлэгч байгууллага болох Адам Смит хүрээлэнгийн захирал ноён Жонатан Пэлл, ЕСБХБ-ны ахлах эдийн засагч ноён Пол Моффат нар манай оронд хүрэлцэн ирж, өчигдөр, уржигдар талуудтай уулзалт хийж тодруулга авч, төслийнхөө шинэчилсэн төлөвлөгөөг эцэслэн боловсруулсан байгаа. За ингээд төслийн шинэчилсэн төлөвлөгөөг танилцуулна уу гэж та бүхнийг уръя.

Пол Моффат: За баярлалаа. Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Намайг Пол Моффат гэдэг. Би ЕСБХБ-наас Монгол Улсын ОҮИТБС-д үзүүлэх техник туслалцааны төслийг хариуцдаг. За энэ хүнийг Жонатан Пэлл гэдэг. Тэрээр төслийг хэрэгжүүлэх

зөвлөх багийн ахлагч байгаа. Энэхүү төслийн зорилго нь та бүхний аль хэдийнэ гаргасан тодорхой амжилт, үр дүнг улам бататгахад оршиж байгаа. Төсөл нь тодорхой 6 асуудлын хүрээнд хэрэгжинэ. Үүнийг илүү дэлгэрэнгүйгээр Жонатан та бүхэнд танилцуулна. Миний хувьд төслийн танилцуулга, яагаад ЕСБХБ нь Монгол Улсын ОҮИТБС-ыг дэмжих болсон талаар товчхон мэдээлэл хийе.

Төсөл нь албан ёсоор 2011 оны 8 дугаар сард хэрэгжиж эхэлсэн ба 2012 оны 1 дүгээр сар хүртэл бид тодорхой ажлууд хийсэн. Тэгээд Монгол Улсын зарим хууль, эрх зүйн орчноос шалтгаалан төсөл түр хугацаанд saatсан байгаа. Гэхдээ бид одоо энэ асуудлыг шийдсэн бөгөөд та бүхэнд төслийг дахин эхлүүлэх санал тавьж, өмнө нь та бүхний гаргаж саналыг тусган төлөвлөгөөг боловсрууллаа.

Яагаад ЕСБХБ нь Монгол Улсын ОҮИТБС-ыг дэмжих болсон тухайд эхлээд ЕСБХБ-ны талаар та бүхэнд товчхон танилцуулмаар байна. ЕСБХБ нь Монгол Улсын уул уурхай, бусад салбаруудад багагүй хэмжээний хөрөнгө оруулалт хийж байгааг та бүхэн мэдэж байгаа байх. Бид танай улсын эдийн засгийн хөгжилд тодорхой хэмжээний хувь нэмэр оруулж байгаадаа таатай байдаг. Аливаа хөгжилд хөрөнгө оруулалт чухал байдаг боловч тогтвортой хөгжлийн бодлого төдийлөн хангалттай бус, хөрөнгө оруулалт нь ард иргэдэд үр өгөөжөө өгөх нь учир дутагдалтай байгааг бид харж байна. Тогтвортой хөгжих, хөрөнгө оруулалтын өгөөжийг ард иргэдэд илүү үр өгөөжтэй болгоход хариуцлагатай байдал, ил тод байдал чухал нелөө үзүүлдэг. ОҮИТБС нь энэхүү хариуцлагатай байдал, ил тод байдлыг олон улсын түвшинд стандарт болгож хэвшүүлэхэд чухал хэрэглүүр болж байгаа юм. Тиймээс ЕСБХБ нь ОҮИТБС-ын хэрэгжилтийг дэмжих үүднээс Монголын ОҮИТБС-д төсөл хэрэгжүүлэхээр болсон ба энэ нь бодит үр дүнгээ өгнө гэдэгт найдаж байгаа. Төсөл нь 6 асуудлын хүрээнд хэрэгжих ба шинэчилсэн төлөвлөгөөнд энэ 6 асуудал хэвээр үлдсэн байгаа. Гэхдээ бид та бүхнээс гаргасан санал, Шинэ засгийн газрын бодлого зэргийг тусган зарим нэг өөрчлөлтүүдийг хийсэн болно. Тухайлбал, та бүхнээс гаргасан саналын дагуу хэд хэдэн ажлыг шинээр тусгасан, төсөл хэрэгжүүлэх шинэ арга аргачлалыг оруулж өгсөн, төслийн багт зарим нэг өөрчлөлт орсон, ялангуяа бид дотоодын зөвлөхүүдийг илүү ажиллуулахыг зорьж байгаа. За ингээд Жонатанг төслийн шинэчилсэн төлөвлөгөөг танилцуулахыг урьяа.

Жонатан Пэлл: Өглөөний мэнд. Пол намайг Адам Смит Хүрээлэнгийн Австрали дахь оффисоос төслийн багт орж ажиллаж байгаа талаар хэллээ. Австрали улсын хувьд уул уурхайн салбар нь эдийн засгийн гол хөшүүрэг болсон, түүнээс нилээн хамааралтай гэдгээрээ танай улстай их адилхан юм. Бас нэг адилхан зүйл гэвэл танай улс ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч орон байгаа, харин Австрали улс нь саяхнаас энэ санаачилгыг илүү нухацтай авч үзэж хэрэгжүүлэхээр зорьж байгаа бөгөөд тэр ч утгаараа ОҮИТБС-ын 6 дахь Олон Улсын бага хурлыг 2013 оны 5 дугаар сард өөрийн орондоо зохион байгуулахаар ажиллаж байна.

Миний хувьд Монголд дахин ирж ажиллах болсондоо баяртай байна. Өмнө нь би 2 жилийн өмнө Дэлхийн банкны төслийн хүрээнд YTEГ-тай хамтран ажиллаж байсан. За ингээд төслийн төлөвлөгөөг танилцуулаяа. Энэхүү төлөвлөгөө нь хоёр хэсгээс бүрдэх бөгөөд нэгдүгээр хэсэргт төслийн хүрээнд хэрэгжүүлэх зорилтууд,

хоёрдугаарт хэрхэн хэрэгжүүлэх талаар тусгаж өгсөн байгаа. Танилцуулгыг хавсаргав.

Н.Баярсайхан: За баярлалаа. Энэхүү төсөл нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд бидэнд дутагдаж байгаа нөөц, чадавхийг бэхжүүлэхэд их чухал ач холбогдолтой юм. Тэгээд ч энэ төсөл нь багагүй хөрөнгөөр хэрэгжинэ. Тийм учраас бид үүнд анхаарлаа хандуулж, саналуудаа сайн тусгаж өгөх хэрэгтэй. За ингээд асуулт, саналтай хүн байна уу?

Б.Баярмаа: Өчигдөр бид уулзалтын үеэр хэлж байсан. Төслийг үр дүнтэй болгохын тулд төслийн мониторинг яж хийх үү? Яг энэ талаар тэр институтыг бэхжүүлэх гэсэн хэсэгт илүү нарийвчлан суулгаж өгөх байх гэж найдаж байна. Хоёрдугаарт, сургалтын хувьд гадаад хүмүүс сургалт хийхээр орчуулгаас эхлээд бэрхшээлтэй, хөрсөнд буудаггүй асуудлууд байдаг. Тиймээс сургалт гэсэн хэсэгт үндэсний зөвлөхийг аль болох ажиллуулах, үндэсний сургагч багш нарыг бэлдэх гэж оруулах саналтай байна. Сургагч багш нарыг аль болох иргэний нийгмээс сонгож бэлтгэвэл бид дараа нь өөрсдөө сургалтаа зохион байгуулаад явах чадавхтай болох юм. Тиймээс энэ талаар анхаараачээ гэж хүсэх байна.

Жонатан Пэлл: Санал гаргаж байгаад баярлалаа. Мониторинг хийх асуудлын тухайд З төрлийн мониторинг хийгдэнэ. Нэгдүгээрт, Адам Смит хүрээлэн нь өөрийн гэсэн олон улсын стандартад нийцсэн мониторинг, үнэлгээ хийх аргачлалтай. Мэдээж бид ч бас энэ төслийг аль болох илүү үр дүнтэй байлгахыг зорьж байгаа. Хоёрдугаарт, ЕСБХБ-ны өөрийн гэсэн үнэлгээний шалгуур үзүүлэлт байдаг. Бид тэр үзүүлэлтүүдийг бүрэн хангаж байх ёстой. Гуравдугаарт, ОУИТБС-ыг Монголд хэрэгжүүлэхтэй, ялангуяа стратегийн бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хийгдэх дотоод хяналтын асуудал байна. Энэ бол их чухал гэдэгтэй би санал нэгдэж байна. Бид өчигдөрхөн институтыг бэхжүүлэх асуудлын хүрээнд ярьж байсан. Тухайлбал ажлын албаны мониторингийг сайжруулах, орон нутаг дахь хариуцлагыг нэмэгдүүлэх замаар орон нутгийн хяналтыг бэхжүүлэх хэрэгтэй байгаа юм. Сургалтын тухайд би тантай санал нийлж байна. Олон улсын түвшинд ажилладаг манайх шиг байгууллагын хувьд орон нутагт ажиллах нь хязгаарлагдмал байдаг. Тиймээс бид та бүхэнтэй хамтран сургалтын хэрэгцээг үнэлж, төлөвлөгөөг боловсруулна. Та бүхний саналыг нээлттэй хүлээж авах болно оо. Бид сургалтыг гадаад хүн ирээд орчуулгатай хийгээд явна гэж төлөвлөөгүй гэдгийг онцолмоор байна.

Б.Адъяа: Хоёр санал байна. Нэгдүгээрт, төслийн хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 6 дахид нь “Гадаадад хийх айчлал” гэсэн байна. Энэ бол зүгээр төслийн хүрээнд бэхжүүлсэн чадавхууд нь гадаад оронд ямар байна гэдгийг харьцуулах, туршлага солилцох маягтай зүйл учраас үүнийг нэг их тусад нь хөтөлбөр болгож, дөвийлгөсөн байдалтай харуулсны хэрэггүй байх. Зүгээр сургалт гэсэн хэсгийн дотор туршлага солилцох аялал гэж оруулбал зүгээр байх. Хоёрдугаарт, төслийн эцсийн баримт бичиг гарах байх. Монгол орчуулга дээрээ сайн анхаарахгүй бол өнөөдрийн бидэнд тараасан энэ материал нилээн ойлгомжгүй болсон байна.

Жонатан Пэлл: Гадаад оронд хийх аялалын тухайд бидэнд хандаж төлөвлөгөөгөө илүү амар, ойлгомжтой боловсруулахад чиглэсэн зөвлөмж байвал бид үүнийг хүлээж авахдаа таатай байх болно. Гадаад оронд хийх айлчлалыг бид бусад хөтөлбөрийн дэд хөтөлбөр болгон оруулж болно. Тухайлбал цахим тайлангийн систем Гана улсад хэрхэн ажилладгийг харья гэх юм бол дэд хөтөлбөрт нь гадаад оронтой туршлага солилцох аялал хийх гэж оруулж болно.

Ш.Цолмон: За баярлалаа. Ерөнхийдөө би төсөлтэй холбоотой талуудыг хариуцан ажиллаж байгаа хүний хувьд мэдээллэлтэй байгаа. Гэхдээ мартагдсан, орхигдсон зүйл байх вий гэдэг үүднээс тодруулах зүйлс байна. Төслийн өртөг, зардлын мэдээллийг бидэнд дэлгэрэнгүй танилцуулж баймаар байна. Гол нь энэ мэдээлэл их хомс байснаас болж төсөл түр saatсан байгаа. Хоёрдугаарт, ОҮИТБС-ын тайланг цахим хэлбэрт шилжүүлэх ажилд нилээдгүй хөрөнгө, мөнгө төсөвлөсөн байсан. Энэ талаар яг тодорхой оруулж өгөөгүй байна. Үүнийгээ тодорхой оруулж өгмөөр байна. Гуравдугаарт, төслийн хүрээнд ажлын хэсгийн гишүүдтэй өргөн хүрээнд хамтарч ажиллах байгаа. Ажлын хэсгийн гишүүд маань санаачилгын ажилд өөрсдийн цаг, зав, хүч хөдөлмөрөө их зарцуулдаг учраас тэдэнд оролцооны урамшуулал тооцох боломжтой юу?

Пол Моффат: Төслийн өртөг зардлын тухайд бид төслийг Сангийн яамд бүртгүүлэх явцад өртөг, зардлын нарийвчилсан тооцоог Сангийн яам, ажлын алба, Үндэсний зөвлөлд хүргүүлсэн байгаа. Үүнийг ажлын хэсгийн гишүүдэд тараасан байх гэж бодож байна. Тийм үү Цолмон?

Ш.Цолмон: Хуучин тооцоо нь хүргэгдсэн байгаа.

Пол Моффат: Өртөг зардлын тооцоог бид шинэчлээгүй байгаа. Бид нэн тэргүүнд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн хүрээнд зөвшилцэх хэрэгтэй байна. Үүнийг эцэслэн тохиролцсоны дараагаар зардлын тооцоог хийх боломжтой. Цахим тайлангийн системийн тухайд бид судалгаа хийж, өртөг ашгийн тооцоо хийж ажлын хэсэг, Засгийн газарт танилцуулна. Оролцооны урамшууллын тухайд үүнийг олгох боломжгүй. Банкны бодлогын хүрээнд энэ нь зөвшөөрөгдөхгүй байх. Тиймээс та бүхнээс хүлцэл өчье.

Б.Батболд: Төслийн хүрээнд бүх аймагт биш юмаа гэхэд ядаж гол гол сумдуудад Санаачилгын мэдээллийн төв байгуулах гэж хөтөлбөрт оруулж өгмөөр байна. Энэ мэдээллийн төвөөр дамжуулан иргэд мэдээллээ авдаг байх нь их чухал ач холбогдолтой.

Пол Моффат: Сайн санал байна. Гэхдээ бидний сургалтын хөтөлбөрт ингэж тусгагдаагүй байгаа. Бид эргээд хөтөлбөрөө харах болно.

Н.Алгаа: Төсөл өнгөрсөн жил хэсэг хугацаанд зогссон байсан. Дахиж сэргэж байгаад нь талархаж байна. Зогссон шалтгааныг хайгаад байх нь дэмий юм болов уу эсвэл цаашид хэрэгтэй ч юмуу сайн мэдэхгүй байна. Гол нь төслийн өртөг, мөнгөтэй холбоотойгоор, зөвлөхүүдийн хөтөлбөрийг батлахтай холбоотойгоор зогссон байсан. Түүнээс гадаадын зөвлөхүүдээс хамаарч зогсоогүй юмаа. Бид өөрсдөө зогсоосон.

Нөгөө бэлгийн морины шүдийг тоолдоггүй гэгчээр санаачилгыг хэрэгжүүлэхэд чинь дэмжлэг үзүүлье гээд байхад нь их багыг нь тоолоод л ингээд гацаагаад байх хэрэггүй байх аа. Цаашид үүн дээр анхаармаар санагдлаа. За тэгээд тодорхой хэдэн санал хэлье. ОҮИТБС-ын тусдаа хуультай байх нь зүйтэй байх аа. Институтыг бэхжүүлэх асуудлыг хуультай нь хамтаар авч хэлэлцэх нь зүйтэй. Хуулиндаа институт нь ямар байх талаар сайн тусгаж өгөхгүй бол үндсэндээ Дэлхийн банкны санхүүжилтээр л ажил явагдаж байна. Дээр нь ашигт малтмалын хуулийг шинэчлэн батлахаас өмнө бид саналаа өгөхгүй бол хоцрох вий гэсэн болгоомжлол байна. За дараа нь сургалтын асуудал байна. Өмнө нь бид сургалт нь ямар агуулгатай байх вэ гэдэг дээр зөвшилцэж чадаагүй байсан. Ер нь бол сургалт нь 2 төрөл байна. Нэг нь тэр компаниудад тайлан гаргах талаарх сургалт байна гэж байгаа юм. Гэхдээ бидэнд өнөөдрийн байдлаар сургалтыг олон нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэхэд анхаарч хиймээр байна. Ер нь санаачилгын тухай зөвхөн Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн хүрээнд мэдээд байдаг үүнээс гараад УИХ, Засгийн газар, компани, олон нийтийн дунд мэдлэг ойлголт тун багатай байна. Тиймээс бүх нийтийг соён гэгээрүүлэх тал дээр анхаарч сургалтаа зохион байгуулах хэрэгтэй. Эрх зүйн орчинтой холбоотойгоор 2012 оны 2 дугаар сард “Компанийн нийгмийн хариуцлага”-ын MNISO26001 гэсэн стандарт батлагдсан байгаа. Хууль боловсруулахдаа энэ стандартыг бас анхаарч үзээрэй гэж зөвлөх байна. Тэгээд өмнөх төлөвлөгөөгөө бodoход энэ шинэ төлөвлөгөөнд бидний хэлээд байсан олон дутагдалтай зүйлүүд нь засагдаж орж ирсэн байна. Техникийн дэд зөвлөлтэй болох юм байна, үндэсний зөвлөхүүдийг түлхүү ажиллуулах юм байна гэх мэт олзуурхууштай зүйлүүд байна аа. За тэгээд төслөө хурдхан л хэрэгжүүлж, үр дүн гаргамаар байна. Энэ төслийн үйл ажиллагаанд гишүүдийгээ идэвхтэй оролцохыг уриалж байна аа.

Жонатан Пэлл: Сургалтын тухайд товчхон хариулахад бид 4 төрлийн олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулна. Эхнийхийг нь Засгийн газрын байгууллагуудтай хамтран зохион байгуулна гэж төлөвлөж байна. Үлдэх 3 төрлийн арга хэмжээний тухайд та бүхнээс санал авахад нээлттэй байгаа. Та бүхэн яж хийвэл илүү үр дүнтэй байх талаар саналаа солилцоорой.

Э.Сумъяа: За төслийн танилцуулга хийсэнд баярлалаа. Би энэ төслийг хамгийн үр дүнтэй байлгах дээр санаа зовдог хүмүүсийн нэг л дээ. Энэ төслийн эцсийн зорилго нь ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд бидэнд тулгараад байгаа хүндрэл, бэрхшээлийг л арилгахад оршиж байгаа юм. Гэтэл өнгөрсөн онд төслийн багийнхны боловсруулсан баримт бичгүүд нь хоосон цаас шахуу зүйл байсан. Би бол үүнийг хоосон цаас гэж баталгаатай хэлж чадна. Гэхдээ одоогийн энэ боловсруулсан төлөвлөгөө нь нилээн тодорхой болж орж иржээ. Гэхдээ хууль гэдэг дээр Монголын хуулиудын судалгаа их хэрэгтэй байгаа юм. Өнөөгийн мөрдөгдөж буй хуулиудыг судлахгүйгээр хуулийн төсөл боловсруулбал энэ цааш явахгүй ээ. Тиймээс зорилго гэдэг дээрээ хуулиуд судлах гэж оруулж өгөөчээ гэж хүсэх байна. Хоёрдугаарт, төрөлжсөн сургалтын модуль боловсруулах гэж оруулж өгмөөр байна. Энэ нь тухайлбал компанийн удирдлага нарт зориулсан, компанийн нягтлан бодогч нарт зориулсан, төрийн байгууллагын ажилчдад зориулсан, иргэдэд зориулсан, ахисан шатны гэх мэт өөр өөр төрөлжсөн модуль байх хэрэгтэй. Энэ нь цаашид бид


сургалтаа явуулахад барьж үлдэх юм болноо. Гуравдугаарт, дотоодын зөвлөхүүдийг ажиллуулах ажил байгаа. Явж явж эдгээр дотоодын зөвлөхүүд л бидэнд үлдэнээ. Гадаадын зөвлөхүүд бол зөвлөмжөө өгөөд л мөнгөө аваад л яваад өгнө. Тиймээс дотоодын зөвлөхүүдийн чадавхийг бэхжүүлэхэд анхаараарай. Ялангуяа би ажлын хэсгийн гишүүдийгээ за яахав төрийн байгууллагуудыг албадахгүй, харин компаниудын бас иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл болсон гишүүдийгээ энэ дотоодын зөвлөх гэдэгт нь өрсөлдөөчээ гэж уриалмаар байна. Та бүхэн зөвлөхийн хэмжээнд бэлтгэгдэж үлдээчээ, мэдээлэлтэй үлдээчээ гэж хүсэх байна. Баярлалаа.

Д.Сэнгэлмаа: Агуулгын хувьд Сумъяа гуайтай санал нэг байна. Харин тэр техникийн дэд хороонд гурван талаас хоёр хоёр гишүүн байна гэж хатуу заасан байна. Ийм байж болно гэхдээ миний хувьд зарчмын өөр саналтай байна. Хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд энэ нь дан ганц ашигт малтмалтай холбоотой зүйл биш юмаа. Энэ бол олон улсын худалдаа, санхүү, байгаль орчин гээд их өргөн хүрээг хамрах бөгөөд олон талын зөвлөхүүдээс санал авах шаардлагатай болно. Тэгэхээр энд бол хоёр хүн хангалтгүй юм. Олон улсад судлагдсан томоохон эрдэм шинжилгээний ажлуудыг монгол хэлнээ хөрвүүлэн орчуулж, олон нийтэд, ажлын хэсгийн гишүүдэд хүргэхэд тодорхой хэмжээний зардал мөнгө хуваарилаачээ гэж хүсэх байна.

Б.Бямбадагва: 4 дүгээр даалгавар буюу Цахим тайлан гэдэг дээр цахим тайлан нэвтрүүлэх боломжтой эсэхийг үнэлэх, тогтоох гэсэн байна. Монгол Улс татварын тайланг мөн уулын ажлын төлөвлөгөөний тайланг цахим хэлбэрээр авдаг болоод удаж байна. Үүнийг үнэлээд байх шаардлага байхгүй гэж бодож байна. Тэр үнэлэх гэсэн хэсгүүдээ хассан нь зүйтэй байх. Түрүүнд Сумъяа гуайн хэлдэгээр Монгол Улсдаа үлдэх ажлуудыг дэмжих саналтай байна.

Н.Баярсайхан: Надад нэг санал байна. Энэ төслийн хүрээнд Үндэсний сургагч багш нарыг бэлдэх хэрэгтэй байна. Иргэний нийгмийн байгууллагууд маш олон сургалтуудыг хийдэг, тэр дундаа үйл ажиллагаанд тулгуурласан сургалтууд хийдэг. ТАН эвслийн хүрээнд орон нутгуудад гурван талт хэлэлцүүлгүүдийг зохион байгуулдаг. Тиймээс иргэний нийгмийн байгууллагуудаас тэр дундаа орон нутагт байнга ажилладаг, нутгийн ард олонтой онцлогт нь тохируулж хамтран ажиллаад сурчихсан иргэний нийгмийн байгууллагуудаас тэр үндэсний сургагч багш нарыг бэлтгэх нь чухал ач холбогдолтой юмаа. Хоёрдугаарт, Сумъяа гуай Үндэсний зөвлөхүүдийг чадавхжуулж авч үлдэх гэж байна. Энэ бас их чухал учраас үүнийг төслийнхөө төлөвлөгөөндөө тусгаж өгөөрэй.

Пол Моффат: Цахим тайлангийн тухайд хариулт өгөхөд одоо байгаа тайлангийн систем нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлангийн үзүүлэлтийг агуулсан гэж бodoхгүй байна. Тиймээс бид эхлээд одоогийн цахим тайлангийн системд юу юу багтсан байгаа талаар судална. За дараа нь мэдээж программ хангамж боловсруулах тухайд монгол компаниуд орж болно. Засгийн газар харин үүнийг зөвшөөрөх ёстой. Сургалтын хувьд хоёр агуулгатай байгаа. Нэг нь сургалт зохион байгуулах ажил байгаа. Бид 12 төрлийн сургалтын модуль



Н.Дорждарь, э. биш 2 бакчар, иккээр бакчар, э. аял, оны бакчар

Н.Алгаа: Дорждариин саналыг дэмжиж байна. Гэхдээ техникийн дэд хороо гэдэг нь төслийг бүхэлд нь удирдах, зангидах хороо болох гээд байна. Тиймээс тэр 6 үндсэн гишүүнтэй байдгаараа байгаад хөтөлбөр тус бүр дээр хүн нэмэгдээд явдаг ч юмуу ингээд явж болж байна.

Пол Моффат: Техникийн дэд хороо нь үндсэн 6 гишүүнтэй байгаад дараа нь асуудал, хөтөлбөр бүр дээр ажлын хэсгээс чиглэл бүрээрээ тодорхой хэдэн гишүүд нэмэгдээд орж болно оо. Гэхдээ үүнийг одоо тодорхойлж хэлэх нь хүндрэлтэй байх.

Н.Баярсайхан: За тэгвэл 6 гишүүнтэй байя, энэ зургаан гишүүнд хэн хэн орохыг талууд хоорондоо зөвшилцэж байгаад хоёр хоёр хүнийхээ нэрийг ирэх долоо хоногт багтаагаад ажлын албанд хүргүүлье гэж тохироё. За одоо харин энэ асуудлын хүрээнд шийдвэрлэх шийдвэрийн төслөө та бүхэнд уншиж танилцуулай. За нэгдүгээрт, төслийг 2012 оны 12 дугаар сарын 14-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр тогтов гэсэн байна. Үүнийг бүгд дэмжиж байна уу? За дэмжиж байна. Хоёрдугаарт, хуулийн төсөл боловсруулах багийг 2013 оны 1 дүгээр сар гэхэд ирж хуулийн үзэл баримтлалаа боловсруулах гэсэн байна. Ер нь бол хуулийн төсөл 2013 оны 2 дугаар сараас өмнө боловсруулахгүй бол УИХ дээр Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга ойрын хугацаанд хэлэлцүүлэгдэхээр байгаа учраас бид үүнээс хоцормооргүй байна. Энэ дээр яаж шийдвэр гаргах вэ?

Д.Батхүү: Энэ хугацааг бид нар зааж өгөх нь буруу юмаа. Харин хугацаандаа үйл ажиллагаа нь хийгдэж байна уу гэдэг дээр хяналт тавих хэрэгтэй.

Н.Баярсайхан: За тэгвэл төслийн багийнхны товлосон хугацааг дэмжье, энэ хугацаанд нь хяналтаа тавъя.

Ш.Цолмон: Нэг хугацааг тодруулахад тэр гадаадад хийх туршлага солилцох аяллын хугацааг 5 сард гэсэн байна лээ. Энэ бол бидний хувьд тохиромжгүй байх. Учир нь яг энэ үеэр Олон улсын бага хуралтай учраас давхцах гээд байна. Үүнийг 10 сард гэж хойшлуулах нь зүйтэй байх.

Жонатан Пэлл: Бидний тавьсан хугацаанууд бүгд эцэслэгдээгүй хугацаа байгаа. Бид энэ хурлын дараагаар хугацаануудаа илүү нарийвчлах төлөвлөгөөтэй байгаа тул та бүх саналуудаа хэлэх нь зүйтэй.

Н.Дорждарь: Төслийн хэрэгжилтийн явцыг хоёр сард нэг удаа ч юмуу ажлын хэсэгт тайлагнадаг, мэдээлдэг баймаар байна. Ингэснээр бид мэдээлэлтэй байж илүү оролцох боломж нээгдэх юм.

Пол Моффат: Тийм ээ энэ бол их зөв зүйтэй санал. Бид Адам Смит хүрээлэнд сар бүр, хоёр сар тутамд үнэлгээ хийж, эргээд мэдээлэлэх гэсэн шаардлага тавьж байгаа.

Д.Батхүү: 2 сар гэхэд хуулийн төсөл бүрэн гарсан байх уу?

Пол Моффат: Бид хуультай холбоотойгоор нилээд зүйл хийсэн байгаа. Цоо шинээр хийх ажил биш учраас хуучин гаргасан баримт бичгүүдээ шинэчлэх, дахиж нэг нягтлах асуудлууд байгаа. Тиймээс амжина гэж бодож байна. Дээр нь нэмж хэлэхэд өнөөдрийн та бүхэнд танилцуулсан төлөвлөгөөг та бүхэн дэмжиж байгаа бол Гансүх даргаас албан ёсны зөвшөөрсөн бичиг авмаар байна. Ингэснээр бид албан ёсоор төслөө эхлүүлэх боломжтой болох юм.

Н.Алгаа: Ерөнхийдөө төслийг дэмжлээ, харин нарийвчилсан хугацааг эргээд ажлын хэсэгт танилцуулаад явах гэж томъёолж шийдвэр гаргаад, хурлын протоколоо хүргүүлж болно.

Н.Баярсайхан: Гэхдээ энэ ажлын төлөвлөгөөнд бидний саяны гаргасан саналуудыг тусгасан эсэхийг бид хармаар байна. Тиймээс эргээд энэ талаар ажлын хэсгийн гишүүдэд имэйлээр хүргүүлээд, саналаа аваад явах уу?

Пол Моффат: Бид эхлээд та бүхний гаргасан саналыг тусгаад Гансүх даргад албан ёсны захидал, төслийн төлөвлөгөөний эцсийн хувилбарыг хүргүүлье. Хувийг бас Цолмонд хүргүүлье. Цолмон та бүхэнд тараана бизээ. Харин эргээд Гансүх даргаас төлөвлөгөөг зөвшөөрлөө гэсэн албан ёсны захидал хүлээн авъя. Ингэвэл илүү албан ёсны болох байх аа.

Н.Баярсайхан: За тэгье. За ингээд нэгдүгээр асуудлыг хэлэлцэж дууслаа. Танилцуулга хийсэн ноён Пол Моффат, Жонатан Пэлл нартаа талархлаа илэрхийлье.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Ажлын хэсгийн гишүүд Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас хэрэгжүүлэх төслийн төлөвлөгөөтэй танилцаж, төслийг агуулгын хувьд бүгд дэмжиж байгаагаа илэрхийлэв.

2. 2012 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн ажлын хэсгийн хурлаар гишүүдийн гаргасан саналыг тусгаж төслийн төлөвлөгөөг эцэслэн Ажлын хэсгийн ахлагч Л.Гансүх болон ажлын албаар дамжуулан Ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлэхээр ЕСБХБ, АСИ-тай тохиролцов.

3. Төслийн эцсийн төлөвлөгөөг зөвшөөрч буйгаа илэрхийлсэн албан ёсны бичгийг Ажлын хэсгийн даргын гарын үсгээр баталгаажуулан ЕСБХБ, АСИ-д хүргүүлэхийг ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд үүрэг болгов.

4. Төслийн явцыг сар бүр Ажлын хэсгийн хуралд танилцуулж, ажлын төлөвлөөний хугацаанд Ажлын хэсэг хяналт тавьж ажиллахаар тогтов.

5. ЕСБХБ, АСИ-ийн санал болгосноор Төслийн техникийн дэд хороог 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулахаар тогтох, нэрсээ 2012 оны 12 дугаар сарын 21-ны дотор ажлын албанд ирүүлэхээр тогтов.

II. **ХЭЛЭЛЦСЭН нь:** Австралийн Сидней хотноо 2013 оны 5 дугаар сарын 23-24-ны өдрүүдэд зохиогдох ОҮИТБС-ын Олон улсын зургадугаар бага хурлын тухай

Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон бага хурлын тухай танилцуулаад саналаа хэлэв. /Танилцуулгыг хавсаргав./

Ш.Цолмон: За энэ бага хуралд бид аль болох өргөн бүрэлдэхүүнтэй оролцмоор байна. Болж өгвөл 10-15 хүний бүрэлдэхүүнтэй байвал зүгээр байна. Зардал мөнгөний тухайд Олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас 4 хүний зардлыг, ажлын албанаас 3-4 хүний зардлыг хариуцах боломжтой. Компаниудын хувьд өөрсдөө зардлаа гаргаад явдаг байгаа.

Н.Дорждарь: Энэ арга хэмжээ их ач холбогдолтой юм. Австралид болох бага хурлын үеэр Санаачилгын дүрмийг өөрчлөх байгаа. Тэгэхээр энэ хуралд аль болох өргөн бүрэлдэхүүнтэй оролцоё гэдэг нь зөв байх. Харин тэр цаанаас дааж байгаа иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчөөр бид дотроо ярилцаад зохицуулагч Н.Баярсайханг томилохоор шийдвэрлэнээ албан ёсоор танилцуулмаар байна. Миний хувьд Олон улсын удирдах зөвлөлийн гишүүн гэдгээрээ зардлаа цаанаас нь даалгуулна. Манай Нээлттэй нийгэм форумын Эрдэнэжаргал захирал зардлаа бас өөрөө даагаад оролцоно гэдгийг албан ёсоор хэлчье. Тэгээд ажлын албанаас даах 4 хүний аль болох 2 хүнийг нь иргэний нийгмийн төлөөллөөс сонгоочээ гэж хүсэх байна. Иргэний нийгмийн байгууллагуудын хувьд зардал мөнгөний асуудал жаахан бэрхшээлтэй байдаг.

За дээр нь энд Рио Тинтогийн төлөөлөг сууж байгааг ашиглаад нэг санал уламжилахад 5 сард Австралид нэгэнт ийм олон хүн очиж байгаа юм чинь Австрали дахь Рио Тинтогийн уурхайг үзүүлэх боломж байгаа юу? Яахав зардал мөнгөний тухайд заавал компаниас гэхгүйгээр өөрсдөө уурхай очих зардлаа хариуцах ч юмуу ингээд дотроо ярьж болох байх аа. Иргэний нийгмийнхан ирээдүйн Оюу Толгойг нүдээр үзэх нь нилээн ач холбогдолтой гэж бодож байна. Үүнийг удирдлагадаа уламжилж албан ёсоор хариу өгөөчээ гэж хүсэх байна.

Б.Баярмаа: Саяны Дорждарийн саналыг үнэхээр дэмжиж байна. Үнэхээр яг ийм бүтээн байгуулалт босох юм байна гэдгийг нүдээр үзвэл ялангуяа эсэргүүцээд байдаг иргэний нийгмийнхны хувьд итгэл үнэмшил төрөх юм болов уу гэж бодож байна.

Н.Баярсайхан: За тэгвэл Австралийн бага хуралд оролцох хүмүүсийнхаа нэрсийг Цолмонд өнөөдрийн дотор албан ёсоор өгье гэж тохироё.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Австралийн Сидней хотноо 2013 оны 5 дугаар сарын 23-24-ны өдрүүдэд зохиогдох ОУИТБС-ын Олон улсын зургадугаар бага хуралд оролцох төлөөлөгчдийн нэрсийг талууд Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд албан шугамаар өгөхөөр тогтов.

III. ХЭЛЭЛЦСЭН нь: Бусад асуудал. ОУИТБС-ын ажлын албаны харилцааны мэргэжилтэн /санхүүгийн мэргэжилтэн/-ийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай

Ш.Цолмон: За энд нэг ийм асуудал байгаа юм. Манай харилцааны мэргэжилтэн С.Батбаяр ажлаасаа гарсныг та бүхэн мэдэж байгаа. Тэгээд шинээр харилцааны мэргэжилтэн авахаар нээлттэй зарласан байгаа. Манай санхүүгийн мэргэжилтэн Б.Дэлгэрмаа энэхүү нээлттэй зарласан харилцааны мэргэжилтний орон тоонд өрсөлдөхөөр материалаа өгсөн юм. Хэрэв энэ сонгон шалгаруулалтанд Б.Дэлгэрмаа тэнцвэл шинээр санхүүгийн мэргэжилтэнг сонгон шалгаруулж авах шаардлагатай болно, хэрэв тэнцэхгүй бол санхүүгийн мэргэжилтний ажилаа хэвээр үргэлжлүүлээд явах юм. Ийм учиртай байгаа юм шүү.

Н.Дорждарь: Сангийн яам, Татварын ерөнхий газарт нэг санал тавьмаар байна. 2011 онд олборлох салбараас орсон орлогыг манай тайлангаар 2,1 их наяд төгрөг байна гэж тодорхойлсон бол Сангийн яам 1,3 их наяд төгрөг байна гэж тодорхойлоод байгаа. Энэ их зөрүүний учир шалтгааныг тайлбарлаж өгөөчээ гэж хүсэх байна. Миний харж байгаагаар манай санаачилгын тайланда олон салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд тайлангаа өгч байгаа. Тухайлбал, Гацуурт ХХК гэхэд газар тариалангийн бизнес эрхэлдэг компани давхар уул уурхайн бизнес эрхлээд компанийн ашгийн татварт нэг л дүн төлж байгаа. Үүнийг яг уул уурхайгаас олсон орлогынх нь татвар нь энэ ээ гэж салгаж харуулах боломж байдаг юм болов уу? Үүнийг тодруулаачээ, ямар гарц шийдэл байна гэдэг дээр зөвлөмж өгөөчээ гэж хүсэх байна. Яагаад гэвэл манай санаачилга бол зөвхөн олборлох салбарын орлогын ил тод байдлыг хангахад чиглэдэг. Хэрэв тэр бусад салбарын орлогыг хамруулаад байгаа бол энэ үндсэн зарчимаасаа хазайсан зүйл болох гээд байна.

Хоёрдугаарт, Батхүү даргаас тодруулах зүйл байна. Олон улсын удирдах хорооноос хэрэгжүүлэгч орны Засгийн газартай гэрээний ил тод байдлыг хэрхэн хангах талаар зөвлөлдөх тийм албан захидал хүргүүлсэн байгаа. Захидлын товч утга нь гэрээний ил тод байдлыг ОУИТБС-тай уяах уу? Тэгээд 4 хувилбар санал болгосон байсан. Нэгдүгээрт, шаардлага болгож оруулая, хоёрдугаарт, тодорхой нөхцөлтэйгээр оруулая гэж байгаа юм. Тухайлбал, зөвхөн шинээр байгуулагдсан гэрээг ч гэдэг юмуу. Гуравдугаарт, нууцлалын зэрэгтэй заалтуудыг нь үлдээгээд бусад заалтуудыг нь ил тод болгох, дөрөвдүгээрт, үүнийг тухайн улс орон нь шийдэх ч гэдэг юмуу. Ийм 4 хувилбартай захиаг Ганхуяг сайдад хаяглан хүргүүлсэн байх ёстой. Энэ захияа нь ирсэн болов уу? Захианы хариуг хүргүүлсэн үү? Хүргүүлсэн бол ямар утгатай хариу хүргүүлсэн бэ? гэж асуумаар байна.

Д.Батхүү: Захиаг ирснийг нь мэдэж байна. Хариу захидлыг нь Стратеги, бодлого төлөвлөлтийг газар боловсруулж байгаа.

Н.Дорждарь: Эцэст нь нэг санал хэлэхэд ажлын хэсгийн хурлаа талууд эзлжлээд хийх нь их зөв зүйтэй санагдлаа. Тэгэхээр цаашид заавал Уул уурхайн ассоциаци дээр гэлтгүйгээр манай Нээлттэй нийгэм форум дээр, за тэгээд компаниудын оролцоо гэдэг утгаараа дараагийн хурлуудыг компаниуд дээр хийвэл яасан юм бэ? гэсэн санал байна.

Н.Баярсайхан: За баярлалаа. Тэгэхээр тэр Дорждарийн хэлдэг уул уурхайн орлогыг салгаж тайлагнуулах гарцыг судлаж Ажлын хэсгийн хуралд танилцуулахыг Сангийн яаманд үүрэг болгох талаар шийдвэрийн төсөлдөө оруулах уу?

Б.Бямбадагва: Энэ жилийн хувьд энэ боломжгүй байх гэж бодож байна. Ашигт малтмалын газраас уулын ажлын төлөвлөгөөгөө хүлээж аваад Татварын ерөнхий газар яг энэ саналыг тавьж байсан л даа. Зөвхөн уул уурхайн татварыг нь салгаад өгөөчээ гэж. Гэтэл Татварын ерөнхий газар 4 дэх жилдээ боломжгүй гэж хариулж байгаа.

Н.Баярсайхан: Энэ бол яалт ч үгүй чухал асуудал л даа. Үүнийг бид цаашид судлах ёстай, анхааралдаа авах ёстай. Тиймээс хурлын протокол дээрээ тэмдэглээд явъя. Өнөөдрийн хуралдаанаас хурлыг талууд ээлжлээд ингээд удирдаад, зохион байгуулаад явах нь ач холбогдолтой гэдгийг та бүхэн ойлгосон байх аа. За ингээд өнөөдрийн хурал өндөрлөлөө. Та бүхэнд амжилт хүсье.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. ОУИТБС-ын ажлын албаны харилцааны мэргэжилтэн /санхүүгийн мэргэжилтэн/-г сонгон шалгаруулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар батлав.

Ажлын хэсгийн хурал 13 цагт 10 минутад өндөрлөв.


Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

ТАН эвслийн зохицуулагч,
Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн


Н.Баярсайхан

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн мэргэжилтэн


Б.Дэлгэрмаа